



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Нийслэлийн ерөнхий боловсролын 42 дугаар сургуулийн баланст бүртгэлтэй, нийт 87,874,449.25 (наян долоон сая найман зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун дөчин есөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн
74 дугаар тогтоолын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСАЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглал -тад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2023.05.01/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	42 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны барилга	1968	Сонгинохайрхан дүүрэг 2 дугаар хороо, Орбитын гудамж	81,742,458.03	19,300,302.81	62,442,155.22	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2020 оны 02-07-101/1066 дугаар дүгнэлт
2	Склад	2018	Сонгинохайрхан дүүрэг 2 дугаар хороо, Орбитын гудамж	6,131,991.22	635,633.40	5,496,357.82	
НИЙТ ДҮН				87,874,449.25	19,935,936.21	67,938,513.04	